

**ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



Монгол Улсын Ерөнхий  
аудиторын баталсан  
төлөвлөгөө, хөтөлбөрийн  
дагуу хийсэн аудитын  
тайлан

**ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦОО,  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /САГ-2018-03-СА/**



**ТӨРИЙН САНГИЙН ТОГТОЛЦООГ БОДЛОГО ЧИГ  
ҮҮРЭГТЭЙ НЬ НИЙЦҮҮЛЖ ӨӨРЧЛӨХ ШААРДЛАГАТАЙ  
БАЙНА**

Чойбалсан хот  
2018 он

Тайланг бэлтгэсэн:  
Дорнод аймаг дахь Төрийн  
аудитын газрын

Дарга бөгөөд Тэргүүлэх  
аудитор Б.Болортуул  
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер  
В.Цэнгэлмаа  
Утас: 70584204

Санхүүгийн аудитын албаны  
Ахлах аудитор  
Д.Нармандах,  
Ж.Баяртуул  
Аудитор  
С.Энхбаатар  
Утас: 70584207

2018 оны 11 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал 7058-  
4204, 7058-4207 дугаарын  
утас болон  
[www.dornod@audit.gov.mn](mailto:www.dornod@audit.gov.mn)  
цахим хаягаар  
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,  
Хэрлэн сум, 7-р баг,  
АЗДТГ-ын 2-р байр,  
2 давхар 04 тоот

## Агуулга

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

**I Бүлэг. Төрийн сангийн тогтолцоог бодлого чиг үүрэгтэй нь нийцүүлж өөрчлөх шаардлагатай байна.**

1.1. Төрийн сангийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна.

1.2. Төсвийн тухай хуульд заасан төрийн сангийн нийтлэг чиг үүргийг нэмэгдүүлж, тогтолцоог чиг үүрэгтэй уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.

1.3. Зарим сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод жишиг зааварт заасан холбогдох чиг үүргүүдийг бүрэн тусгаагүй байна.

1.4. Төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах бодлого тусгагдсан ч хүрэх үр дүнг тодорхойлоогүй, биелэлтийг бодитой үнэлээгүй байна.

**II Бүлэг. Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.**

2.1. Төрийн сан нь хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. ЗГСМУС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна.

2.3. Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

**ДҮГНЭЛТ**  
**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ**  
**ЗӨВЛӨМЖ**  
**ТУШААЛ**  
**ТӨЛБӨРИЙН АКТ**  
**АЛБАН ШААРДЛАГА**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
<b>ҮАГ</b>	Үндэсний аудитын газар
<b>ИТХ</b>	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
<b>МУ</b>	Монгол Улс
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>САГ</b>	Санхүүгийн аудитын газар
<b>СА</b>	Санхүүгийн аудит
<b>ТЕЗ</b>	Төсвийн ерөнхийлөн захирагч
<b>АЗДТГ</b>	Аймгийн Засаг даргын Тамгын газар
<b>ЗДТГ</b>	Засаг даргын Тамгын газар
<b>ЗД</b>	Засаг дарга
<b>СС</b>	Сангийн Сайд
<b>НАА</b>	Нийтийн аж ахуй
<b>ХХК</b>	Хязгаарлагдмал Хувьцаат Компани
<b>ЗГСМУС</b>	Засгийн газрын санхүүгийн мэдээллийн удирдлагын систем
<b>НД</b>	Нийгмийн даатгал
<b>ОНХС</b>	Орон нутгийн хөгжлийн сан
<b>СТСХ</b>	Санхүү төрийн сангийн хэлтэс

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:****Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

**Аудитын зорилт:**

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж, дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
- Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

**Аудитын хамрах хүрээ:**

Аудитад аймаг, 12 сумын төрийн сангийн нэгж, зарим төрийн байгууллагуудыг хамруулсан бөгөөд 2017 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн.

**Үндсэн мэдээлэл:**

Дорнод аймагт аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэс нь аймгийн Засаг даргын 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн А/09 захирамжаар хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогч, бүртгэл хариуцсан ахлах мэргэжилтэн, төсвийн ахлах мэргэжилтэн, төсвийн байгууллага хариуцсан 3 мэргэжилтэн гэсэн 7 хүний бүрэлдэхүүнтэй, 13 сум нь төрийн сангийн алба, Хэрлэн сум төрийн сангийн төлөөлөгч, төрийн сангийн мэргэжилтэн гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар нийт 64 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна.

**Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ Гүйцэтгэлийн аудитын стандарт (АДБОУС 3000-3100, гарын авлага, журам, удирдамжид заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, санал асуулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, ажиглалт хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

**Аудитын шалгуур үзүүлэлт:**

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

**Хууль**

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Бусад холбогдох хуулиуд

**Засгийн газрын тогтоол:**

- Санхүүгийн алба байгуулах тухай /2014 оны №326/
- Төрийн сангийн үйл ажиллагааны журам /2012 оны №205/

**Сангийн Сайдын тушаал:**

- Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам /2012 оны №276/
- Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам /2012 оны №294/
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт зохицуулалт хийх, Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам /2013 оны №73/
- Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансны Монгол банк, арилжааны банканд нээх, хаах журам /2013 оны №24/24/А-9/
- Төрийн сангийн нэгдсэн дансны чөлөөт эх үүсвэрийг удирдах журам /2014 он/
- Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам /2014 оны №65/
- Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх журам /2014 оны №95/
- Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар /2015 оны №90/
- Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам /2016 оны №415/

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, Ж.Баяртуул, аудитор С.Энхбаатар нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Аудитын хугацаа:**

Аудитыг 2018 оны 07 дугаар сарын 16-ны өдөр эхэлж 11 дүгээр сарын 05-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж ҮАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

**Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 2 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Тэргүүлэх аудиторын тушаалаар батлууллаа.

**БҮЛЭГ I. Төрийн сангийн тогтолцоог бодлого чиг үүрэгтэй нь нийцүүлж өөрчлөх шаардлагатай байна.**

**1.1. Төрийн сангийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна.**

Төсвийн тухай хуулийн 4.1.40-д төрийн сангийн үйл ажиллагаа гэсэн нэр томъёог “Төрийн сангийн үйл ажиллагаа гэж төсөв, мөнгөн хөрөнгө, өр төлбөрийн

удирдлагыг хэрэгжүүлэх төлбөр тооцоог гүйцэтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах” гэж тайлбарласан байна.

Төсвийн тухай хуулийн 37.1-д төрийн сан 8 нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан бөгөөд эдгээр чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг Засгийн газрын тогтоолоор батлахаар тусгасан. Засгийн газрын тогтоолоор батлагдсан “Төрийн санд нээсэн төсвийн хэрэгжилт, төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагааг хангахтай холбоотой төсвийн ерөнхий данс болон бүртгэлийн дансны бэлэн бөгөөд бэлэн бус төлбөр тооцоо болон бусад харилцааг энэхүү журмаар зохицуулна.” гэж заасан.

Эдгээр хууль, журамд заагдсан чиг үүргүүд нь батлагдсан төсвийг хэрэгжүүлэхтэй холбоотой байгаа бөгөөд харин санхүүгийн удирдлагын төлөвлөлт буюу батлагдахаас өмнөх чиг үүрэг тусгагдаагүй байна. Харин Сангийн Сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-т төсвийн төслийг боловсруулахтай холбоотой ажлууд тусгагдсан байна.

Төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй зарим хууль тогтоомж, журам, зааврын заалтууд хоорондоо болон холбогдох хуулийн заалтуудтай уялдахгүй байна. Тухайлбал:

1. *Төсвийн тухай хуулийн 8.9.8-д төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2 дугаар сарын 15-ны дотор хүргүүлж 3 дугаар сарын 15-ны дотор дүгнэлтээ гаргуулан авч харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж, нэгтгүүлэхээр заасан. Харин хуулийн 8.9.3-т сумын төрийн сан сумын санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны дотор Төрийн аудитын байгууллагад хүргүүлж 3 дугаар сарын 25-ны дотор дүгнэлтээ гаргуулан авч дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр заасан байна. Энэ нь тухайн сумын нэгтгэлд орох орон нутгийн өмчит газрын санхүүгийн тайланд аудитын байгууллагын дүгнэлт гараагүй байх хугацаанд сум нь нэгтгэсэн тайлангаа хүргүүлэхээр заасан нь хугацааны хувьд уялдахгүй байна.*
2. *Төсвийн тухай хуулийн 6.3.1-д "төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг бууруулах бичилт хийхгүйгээр нийт дүнгээр нь төлөвлөж, тайлагнах," гэж заасан боловч Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.11-д<sup>1</sup> "тухайн байгууллагын данснаас дараах тохиолдолд орлого бууруулах гүйлгээ хийхийг зөвшөөрнө." гэж заасан байна.*

<sup>1</sup>7.11.1. улсын болон орон нутгийн төсвийн, нийгмийн даатгалын сангийн орлогын төвлөрүүлэлт, хуваарилалт;

7.11.2. төсвийн ерөнхий дансанд үлдэгдлийг төвлөрүүлэх;

7.11.3. нэр, данс зөрүүтэй орлогыг;

7.11.4. нийгмийн даатгалын сан, даатгалын компаниас тухайн даатгуулагчтай холбоотой даатгалын төлбөрийг;

7.11.5. гадаад орон, олон улсын байгууллага, дээд шатны төсвийн эрх захирагчаас олгосон арга хэмжээний санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг санхүүжүүлсэн байгууллагад шилжүүлэх;

7.11.6. барьцаа хөрөнгийн зориулалтаар орж ирсэн орлогыг тухайн мөнгө тушаасан байгууллага, иргэнд шилжүүлэх;

7.11.7. ялтны хөдөлмөрийн хөлс;

7.11.8. тендерийн орлогоос зөвхөн тендер зохион байгуулахтай холбоотой урсгал зардал (Худалдан авах ажиллагааны алба, газарт энэ хэсэг хамаарахгүй)

7.11.9. ажлын байр, сургалтын төлбөрийн буцаалт;

7.11.10. сумдын аймагт шилжүүлсэн халамжийн сангийн санхүүжилтийг банканд хуваарилах;

7.11.11. төсвийн байгууллагын бүртгэлийн данс өөрчлөгдсөнтэй холбоотой дансны үлдэгдлийг шилжүүлэх.



3. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.6-д “.... аймаг, нийслэлийн төрийн сан нь сум, дүүргийн төрийн сангийн үйл ажиллагаанд санхүүгийн дотоод хяналтыг тус тус хэрэгжүүлнэ.” гэж заасан. Аймгийн төрийн сан нь дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ Сангийн Сайддын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан журмын 5.2-д “Журмын 4 дэх хэсэгт заасан хяналтыг явуулахдаа 5.1-д заасан эрсдэлд суурилна.” гэж заасан байна. Харин журмын 5.1.1-д “Тухайн төрийн сангийн эрсдэлийг .... суманд төрийн сангийн төлөөлөгч, .... маягт, зааврын дагуу үнэлж, эрсдэлийн түвшинг тодорхойлно.” гэж заасан нь аймгийн төрийн сан сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэхдээ сумдын өөрсдийнх нь тодорхойлсон эрсдэлд сууриллахаар байгаа нь хоорондоо уялдахгүй байна.
4. Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3-т “Суманд үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нээгдсэн алба байгуулж болно.”, 36.4-т “Нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх алба байгуулах асуудлыг санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр аймгийн Засаг дарга шийдвэрлэнэ.” гэж заасан байхад сумдад санхүүгийн албыг байгуулах талаар гаргасан аймгийн Засаг даргын шийдвэр байхгүй байна. Сумдад санхүүгийн албыг Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолын дагуу байгуулсан байна. Уг тогтоолын 1 дүгээр заалтад сумдад санхүүгийн алба байгуулсугай гэсэн нь төв байгууллага зөвшөөрөл олгосноор Засаг дарга шийдвэрлэх тухай хуулийн заалттай нийцэхгүй байна.
5. ЗГСУМС-д мөрдөх журмын 3 дугаар зүйлд заасан эрхүүдийг нэг албан тушаалтанд давхардуулан олгохгүй бөгөөд өөрт оногдсон эрхээс өөр эрхээр системд нэвтэрч ажил үүрэг гүйцэтгэхийг хориглоно гэж заасан нь төрийн сангийн үйл ажиллагаанд тавих хяналтыг бий болгосон. Гэтэл энэ журмын 5.9-д 3 дугаар зүйлд заасан хориглох заалт нь сумын санхүүгийн албаны албан тушаалтанд хамаарахгүй байхаар тусгасан нь өмнөх заалтаар тодорхойлсон хяналтыг эргээд сулруулахад хүргэж байна.

Иймд төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй дээрх хууль тогтоомжийн заалтуудыг уялдуулах шаардлагатай байна.

**1.2. Төсвийн тухай хуульд заасан төрийн сангийн нийтлэг чиг үүргийг нэмэгдүүлж, тогтолцоог чиг үүрэгтэй уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.**

Сумдад санхүүгийн алба байгуулагдахаас өмнө Төсвийн тухай хуульд зааснаар сумын төсвийн ерөнхий нягтлан бодогчийг сумын Засаг дарга, төсвийн мэргэжилтнийг ЗДТГ-ын дарга, төсөвт байгууллагуудын нягтлан бодогчдыг тухайн байгууллагын дарга нар томилж байсан. Алба байгуулагдсанаас хойш албаны ажилтнуудыг томилсон албан тушаалтан нь харилцан адилгүй байна. Сумдаас Баянтүмэн, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан сумдад санхүүгийн албаны даргыг ЗДТГ-ын даргын тушаалаар, бусад сумдад Засаг даргын захирамжаар томилсон байна. Харин санхүүгийн албаны төсвийн мэргэжилтэн, төсөвт байгууллагын нягтлан бодогчдыг бүх сумдад ЗДТГ-ын даргын тушаалаар томилсон байна. Энэ асуудлыг зохицуулсан эрх зүйн орчныг тодорхой болгох шаардлагатай байна.

Мөн сумдын санхүүгийн албаны ажилтнуудыг томилсон албан тушаалтнууд нь тухайн шатныхаа төсвийн захирагчид байгаа нь томилсон албан тушаалтандаа эргэж хяналт тавих харилцааг үүсгэж байна. Энэ нь төрийн сан нь хяналт тавих чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх, гүйцэтгэл дутуу болон баримтын бүрдэл дутуу гүйлгээг хийх нөхцөл байдлыг бий болгож байна.

Сумдад алба байгуулах тухай ЗГ-ын 2014 оны 326 дугаар тогтоолын дагуу аймгийн хэмжээнд нийт 14 сумаас 13 сумд нь санхүүгийн албыг байгуулсан байна.

Хэрлэн сум нь санхүүгийн алба байгуулаагүй байгаа бөгөөд шалтгааныг аймаг, сумын төрийн сангийн холбогдох албан тушаалтнаас тодруулахад “Хэрлэн сум нь харьяа төсвийн 42 байгууллагатай. Засгийн газрын тогтоолоор 3-аас 5-н төсвийн байгууллагын дунд 1 нягтлан бодогчтой байх тохиолдолд ажлын ачаалал их болно, ажлын хариуцлага буурах хүндрэл гарч байгаа.” гэсэн тайлбарыг өгсөн.

Засгийн газрын тогтоол нь бүх сумдад хамаарах тул энэ нь алба байгуулахгүй байх үндэслэл биш хэдий ч эдгээр нөхцөл байдлыг харгалзан аймгийн төвд байгаа сумын хувьд санхүүгийн албыг байгуулах болон байгуулахгүй эсэх тухайг холбогдох дээд шатны байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэх шаардлагатай байна.

Орон нутгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг боловсруулах үе шатан дахь төрийн сангийн холбогдох чиг үүргийг хууль, журамд тодорхой тусгаагүйгээс Төрийн аудитын байгууллагаас төсвийн төсөлд санал, дүгнэлт өгөхөд хүндрэл үүсдэг. Тухайлбал: төсвийн төслийг тооцоо судалгаанд үндэслэн боловсруулахаар заасан ч уг тооцоо судалгааг хариуцан гүйцэтгэх хэлтэс, алба тодорхойгүй байдгаас холбогдох алдаа, зөрчлийг залруулах, албан тушаалтанд хариуцлага тооцох, ажил хүндрэлтэй байдаг.

Иймд Төсвийн тухай хуульд заасан төрийн сангийн чиг үүргийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**1.3. Зарим сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод жишиг зааварт заасан холбогдох чиг үүргүүдийг бүрэн тусгаагүй байна.**

Аймаг, сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтууд нь 2015-2018 онд боловсруулагдан батлагдсан байна.

Аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн 7 ажилтан, 13 сумын санхүүгийн албаны 39 ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгасан чиг үүргүүдийг Сангийн Сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын холбогдох ажилтанд хамаарах заалтуудтай харьцуулсан судалгаа шинжилгээг хийж үзэхэд:

- Жишиг зааврын дагуу сумдын санхүүгийн албаны дарга 26, төрийн сангийн мэргэжилтэн 15, нягтлан бодогч 7 чиг үүргийг хэрэгжүүлэхээр байна. Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн 7 ажилтан, Баян-Уул, Булган, Сэргэлэн, Цагаан-Овоо, Чойбалсан сумын санхүүгийн албаны 12 ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод холбогдох зааварт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд бүрэн тусгагдсан байна.
- Баяндун сумын хувьд санхүүгийн албаны даргын 5, төрийн сангийн мэргэжилтний 9, нягтлан бодогчийн 4;
- Баянтүмэн сумын хувьд санхүүгийн албаны даргын 15, төрийн сангийн мэргэжилтний 6, нягтлан бодогчийн 3;
- Дашбалбар сумын санхүүгийн албаны даргын 15, төрийн сангийн мэргэжилтний 5, нягтлан бодогчийн 4;
- Халх гол сумын хувьд санхүүгийн албаны даргын 15, төрийн сангийн мэргэжилтний 5, нягтлан бодогчийн 4;
- Хөлөнбуйр сумын хувьд санхүүгийн албаны даргын 16, төрийн сангийн мэргэжилтний 6, нягтлан бодогчийн 2;



- Хэрлэн сумын хувьд төрийн сангийн төлөөлөгчийн 17, төрийн сангийн мэргэжилтний 8;
- Гурванзагал сумын хувьд санхүүгийн албаны даргын 14, төрийн сангийн мэргэжилтний 8, нягтлан бодогчийн 2;
- Чулуунхороот сумын санхүүгийн албаны даргын 16, төрийн сангийн мэргэжилтний 8, нягтлан бодогчийн 3 чиг үүрэг ажлын байрны тодорхойлолтод тус тус тусгагдаагүй байна.

Аудитын явцад төрийн сангийн чиг үүрэгтэй бусад газар, хэлтсүүдийн ажлын чиг үүрэг давхцаж байгаа эсэхийг үзлээ.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/09 дүгээр захирамжаар аймгийн ЗДТГ-ын бүтэц зохион байгуулалтыг санхүү, төрийн сангийн хэлтэс, төрийн захиргааны хэлтэс, хууль, эрх зүйн хэлтэс, нийгмийн бодлогын хэлтэс, хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтэс, цэргийн штаб, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн гэж 7 хэлтэстэй байхаар баталсан.

Эдгээр хэлтсүүдээс хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс бусдад нь санхүү, төсвийн асуудалтай холбоотой ажлын чиг үүрэг байхгүй байгаа бөгөөд хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн санхүү, төсвийн асуудалтай холбогдох хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг аудитын явцад ирүүлээгүй бөгөөд баталгаажсан тодорхойлолт байхгүй гэсэн тайлбарыг өгсөн.

Иймд дээрх Төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг холбогдох чиг үүрэгт нь нийцүүлэн өөрчилж, хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн санхүү, төсвийн асуудалтай холбоотой мэргэжилтний чиг үүргийг тодорхой болгож, ажлын байрны тодорхойлолтыг батлах шаардлагатай байна.

#### **1.4 Төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах бодлого тусгагдсан ч хүрэх үр дүнг тодорхойлоогүй, биелэлтийг бодитой үнэлээгүй байна.**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6.1-д "Хөгжлийн бодлогын баримт бичиг нь дэвшүүлж байгаа зорилго, зорилтоосоо хамааран урт, дунд, богино хугацааны гэсэн төрөлтэй байна" гэж заасан бөгөөд аймгийн Засаг дарга нь дунд хугацааны бодлогын баримт бичиг болох "аймгийн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр"-т төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр нийт 9 зорилтыг тусган батлуулсан байна.

Дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулахын тулд тухайн жилд хамаарах зорилт, арга хэмжээг богино хугацааны бодлогын баримт бичигт тусгахаар хуульчилсан.

Аймгийн 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой зорилтуудаас аймгийн 2017 оны эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дараах 3 зорилтыг тусгажээ. Үүнд:

1. Сумдын төрийн сан, төсвийн байгууллагуудын төсөв, санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, өмнөх оны хяналт шалгалтын ажлын үр дүнг сайжруулах.

2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хамрах хүрээний бүх шатны төсөвт эерэг, сөрөг хандлагуудыг тэнцвэржүүлэн, аймгийн 2017 оны төсвийн тэнцлийг бүрэн хангаж ажиллах.
3. Төсвийн мэдээллийн ил тод, үнэн зөв зарчмыг хэрэгжүүлэх, тайлагнах хүрээнд санхүү, төсвийн программын шинэчлэлийг хийж, сумдын болон төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтан, албан хаагчдад салбарын шинэчилсэн программ хангамж, бүртгэл, санхүү, төсвийн хуулийн талаарх сургалтыг зохион байгуулах.

Аймгийн дунд болон богино хугацааны стратеги зорилтод төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулах зорилго, зорилтыг тусгасан боловч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16.1-д “*Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна*”, 18.1-д “*Дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын баримт бичигт төсөв, санхүүгийн тооцоолол, эх үүсвэрийг нарийвчлан тусгасан байна*” гэж заасны дагуу дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний хүрэх үр дүнг, хэрэгжүүлэх төсөв санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхой тусгаагүй байгаа бөгөөд аймгийн ИТХ нь хуульд нийцүүлэн боловсруулаагүй бодлогын баримт бичгийг баталсан байна.

Мөн Сангийн Сайд болон аймгийн Засаг даргын 2017 онд хамтран ажиллах 16 заалт бүхий гэрээнд төрийн сангийн үйл ажиллагаа, үр нөлөөг сайжруулах талаар:

1. *Хүний нөөцийг чадавхжуулахтай холбоотой* - Орон нутгийн нягтлан бодогч нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалт хөтөлбөрт хамруулах тухай гэрээний 3.1, 3.4 3.16 заалтуудад,
2. *Нийтлэг чиг үүргийн хэрэгжилттэй холбоотой* - НД-ын сангийн төсвийн орон нутаг дахь хэрэгжилт, улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилтийг баталсан хуваарийн дагуу төрийн сангаар дамжуулан гүйцэтгэх, орлогыг цаг хугацаанд төвлөрүүлэх, ОНХС-ийн үйл ажиллагаа болон орон нутагт зохион байгуулагдах худалдан авах ажиллагаанд хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээ тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэх тухай 3.2, 3.3, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11, 3.13, 3.15, 3,16 заалтуудад,
3. *Хяналтыг сайжруулахтай холбоотой* - “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын дагуу аймгийн СТСХ болон сумдын албадад дотоод хяналтыг хийх, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах тухай 3.12 дахь заалтад тус тус тусгасан байна.

Аймгийн Засаг даргын Сангийн Сайдтай байгуулсан гэрээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу үнэлж “А” үнэлгээтэй дүгнэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой 3 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга

хэмжээний биелэлтийг ИТХ 70 хувиар үнэлсэн байна. Энэ нь аймгийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн дундаж үнэлгээнээс 14 хувиар доогуур үнэлэгдсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч ЗДТГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд Төрийн сангийн үйл ажиллагааг сайжруулахаар тусгагдсан 3 зорилтын хүрээнд 5 үйл ажиллагаа хэрэгжүүлснийг 100 хувь "А" гэж үнэлсэн байна.

Харин аймгийн ЗДТГ-ын даргын СТСХ-ийн даргатай байгуулсан 2017 оны үр дүнгийн гэрээнд 3 зорилтын хүрээнд тусгагдсан 10 үйл ажиллагааны хэрэгжилтийг 83 хувиар үнэлсэн байна.

Аймгийн үндсэн чиглэл болон холбогдох нэгжүүдтэй байгуулсан үр дүнгийн гэрээнд Төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой тусгагдсан заалтууд нь ТЕЗ-ийн Сангийн Сайдтай байгуулсан гэрээний үнэлгээнүүд нь хэт зөрүүтэй байна.

Мөн Төрийн аудитын газраас хийгдсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитуудаар ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС, төсвийн зарцуулалтын гүйцэтгэл, тайлагналтай холбоотой хууль, журамд нийцээгүй зөрчлүүд давтан гарч, уг зөрчлийг арилгахаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Цаашид аймгийн СТСХ нь төсвийн ерөнхийлөн захирагчийн Сангийн Сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бодитой тооцоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

## **БҮЛЭГ II. Төрийн сангийн үйл ажиллагааны үр дүн хангалттай хэмжээнд хүрэхгүй байна.**

### **2.1 Төрийн сан нь хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна**

Дорнод аймгийн төвийн болон 12 сумдын төсөвт байгууллагыг хамруулан Төрийн сан нь төлбөр тооцоог хууль, журмын дагуу гүйцэтгэсэн эсэхийг шалгах явцад дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- *Байгууллагын тамга төлбөрийн хүсэлтэд дарагдаагүй, 1, 2 дугаар гарын үсгийн аль нэг нь зурагдаагүй, төлбөрийн хүсэлтэд төрийн сангийн мэргэжилтний гарын үсэг зурагдаагүй, тэмдгээр баталгаажуулаагүй 565,5 сая төгрөгийн 170 гүйлгээ хийгдсэн байна.*
- *Мөн Дашбалбар сумын Төрийн сангийн албанд Цэцэрлэгийн эрхлэгч 2 сар албан үүргээ гүйцэтгээгүй байх хугацааны 27 ширхэг 14,5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, гарын үсгээр баталгаажсан байна. Мөн Чулуунхороот сумын төрийн сангийн мэргэжилтэн ажилдаа ирээгүй 12 хоногийн хугацаанд 109 ширхэг 51,8 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж гарын үсгээр баталгаажсан байна.*

Энэ нь "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.13.5-д "энэхүү журмын 7.1, 7.2, 7.3-т заасан бүрдэл болоогүй гарын үсгээр гүйлгээ хийх"-г хориглоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Мөн уг аудитын явцад төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ.

- Гурванзагал, Чойбалсан, Цагаан-Овоо, Дашбалбар сумдын зарим төсвийн байгууллагууд ээлжийн амралтын мөнгийг олгоходоо өмнөх жилийн ээлжийн амралтын олговрыг дундаж цалинд давхардуулан тооцон 3,4 сая төгрөгийг олгосон байна.
- Гурванзагал сумын сургуулийн захиралд жилийн эцсийн үр дүнгийн урамшууллыг аймгийн болон сумын Засаг даргын захирамжаар 293621 төгрөгөөр давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-т “Төсвийн гүйцэтгэлийн хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “... ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын Сайдын 2000 оны 166 дугаар тушаалаар батлагдсан “Ээлжийн амралтын олговор тооцох журам”-ын 7-д “Тухайн ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо өмнөх ажлын жилийн ээлжийн амралтын олговрыг тооцоход оруулсан хугацааны дундаж цалин хөлсийг давхардуулан оруулж тооцохгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Аймгийн ТЕЗ-ийн багцад нийт 588 данс төрийн санд байршиж байна. Үүнээс орлогын 268, түр горим буюу барьцаа хөрөнгийн байршуулах 15, хөрөнгө оруулалтын болон халамжийн сангийн 2, төсөвт байгууллагуудын бүртгэлийн 140, нэмэлт орлогын 132, тусгай сангийн 31 данс тус тус байна. Эдгээр дансдыг “Засгийн газрын болон төсвийн байгууллагын дансыг Монгол банк, арилжааны банканд нээх, хаах журам”-ын дагуу нээсэн бөгөөд зориулалтын дагуу ашиглаж байна.

Төрийн сангийн нэгдсэн данс болон мөнгөн хөрөнгийн удирдлагын чиг үүргийн хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- АЗДТГ-ын барилгын ажилд 2017 онд 932,5 сая төгрөгийн санхүүжилт олгогдохоор тусгагдсанаас, 802,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, 130,5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсөвт төвлөрүүлэлгүй аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд авч үлдсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7-д “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ”, Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 8 дугаар зүйлийн 8.13.3-д “Төсвийн байгууллагын зарцуулаагүй дансны үлдэгдлийг Төв төрийн сангаас хүргүүлсэн удирдамжийн дагуу татан төвлөрүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Нийгмийн даатгалын хэлтэс нь Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга болон ХААН, Төрийн, Хас, Капитал, Голомт, Худалдаа хөгжлийн банкуудын гүйцэтгэх захиралтай Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2010 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банкт хамтран ажиллах журам”-ын дагуу хамтран ажиллах гэрээг байгуулан сар бүрийн эцэст “Тэг” үлдэгдэлтэй орлогын дансдын хүүгийн орлогыг төвлөрүүлэн тооцоо нийлж баталгаажуулан ажилласан байна.
- Төрийн сангийн дансны чөлөөт үлдэгдлийн хувьд Дорнод аймагт чөлөөт эх үүсвэрийн мөнгөн хөрөнгийн данс байхгүй байна. Харин байгаль хамгаалах

сангийн дансанд 2016-2017 онд хайгуулын лицензтэй 12 компаниудаас байршуулсан нийт 123,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Аймаг сумын Төрийн сангийн нэгж нь 2017 онд 94 ажил гүйлгээг алдаатай хийсэн байгаа бөгөөд нийт алдаатай гүйлгээний 85,1 хувийг сумын төрийн сан, 14,9 хувийг аймгийн төрийн сан хийсэн байна.

Төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах чиг үүргийн хувьд дараах байдалтай байна.

- Аймаг, сумдын төсвийн байгууллагууд нь төсвийн сар, улирлын хуваарийг хийн аймаг, сумын Засаг даргаар баталгаажуулсан байна. Мөн аймаг, сумдын төсвийн байгууллагуудын баталгаажуулсан төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн хэлбэлзэлтэй тулган шалгахад тохирч байна.
- Сумдын санхүүжилтийн эрхийг сар бүрийн 15-наас хойш нээж байна. Энэ нь СС-ын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-д заасан хугацаанд төсөвт байгууллагуудын санхүүжилтийн эрхийг олгосон эсэхийг шалгахад сумдын төсвийн байгууллагуудын санхүүжилтийг сар бүрийн ажлын эхний 5 хоногт багтаан олгоно гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн санхүүжилтийн эрх сангийн яамнаас сар бүрийн 8-наас хойш нээгдэж, аймгийн төсвийн орлогын биелэлт бүрэн хангагдахгүй байгаа зэргээс шалтгаалан сумдын санхүүжилтийн эрхийг сарын сүүлээр нээж байна.

- Нэмэлт төсвийн зарцуулалтын 3275,1 сая төгрөгийн гүйцэтгэлийг СС-ын 2013 оны 73 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам"-ын 7 дугаар зүйлд заасан НТ№1 маягын дагуу гарган тайлагнасан байна.


## **2.2 ЗГСМУС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна.**

Аймаг, сумдын санхүүгийн албаны нийт 34 ажилтан "Засгийн газрын санхүүгийн мэдээллийн удирдлагын системд мөрдөх журам"-ын 3 дугаар зүйлд заасан системд нэвтрэх хэрэглэгчийн ажил үүргийн ангиллын дагуу системд нэвтрэн ажил үүргээ гүйцэтгэж байна. 2017 онд ажил албан тушаалаас халагдсан, чөлөөлөгдсөн болон хүүхэд асрах чөлөөтэй 18 хэрэглэгчийн эрхийг түр хугацаагаар шилжүүлсэн байна.

ЗГСМУС хэрэглэгчдээс авсан судалгаа, хийсэн ярилцлагаар ажил гүйлгээг бүртгэх, системд импортлох ажлыг хөнгөвчилсөн боловч, ачаалалтай үед гацдаг тухай 25 хувь нь, хурдыг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа тухай 37,5 хувь нь дурдсан байна. Үүнээс шалтгаалан гүйлгээг баталгаажуулах явцад гүйлгээ орхигдсон эсэхийг дахин хянаж, хэд хэдэн удаа давтан гүйцэтгэдэг байна.



Графикаар харуулбал



Дээрх санал асуулгын дүн нь программ хангамж хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа ч сумдын сүлжээний хурдыг нэмэгдүүлсэн нөхцөлд хэвийн үйл ажиллагаа нь хангагдахаар байгааг харуулж байна.

Сумдын санхүүгийн албадын ашиглаж буй суурин болон зөөврийн компьютерүүд нь өртгөө бүрэн нөхөж, ашиглалтын хугацаа нь дууссан мөн вирусийн эсрэг программ суугдаагүй байна.

### **2.3 Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.**

Сангийн Сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-д заасны дагуу аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/164 тоот захирамжаар хяналтын ажлын төлөвлөгөөг батлуулж, 14 сумын төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг нэгтгэн Сангийн Яамны Төрийн сангийн газарт хүргүүлсэн байна.

“Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.2 дахь хэсэгт “дотоод хяналтыг явуулахдаа 5.1-д заасан эрсдэлд суурилна” гэсэн заалтын дагуу аймаг, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг хийсэн байна. Уг үнэлгээгээр Халхгол, Матад сумд нь хамгийн өндөр эрсдэлтэй бусад сумд бага, дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна.

Хяналтыг хийхдээ эрсдэлийг харгалзана гэж журамд заасан ч бүх сумдыг хамруулсан байна.

*Дотоод хяналтын тайлангаар өгөгдсөн  
зөвлөмжийг ангилж харуулбал*

д/д	Сумдын нэр	Төлбөр тооцооны хяналтын ү/а	Төсвийн хэрэгжилтийн ү/а	Мөнгөн хөрөнгийн ү/а	Нийт	Эзлэх хувь
1	Баяндун	12	0	0	12	8.8
2	Баянтүмэн	0	0	0	0	0
3	Булган	12	0	0	12	8.8
4	Гурванзагал	12	0	0	16	11.8
5	Дашбалбар	16	0	0	4	2.9
6	Матад	9	0	0	9	6.6
7	Халхгол	10	0	0	10	7.4
8	Хөлөнбуйр	15	0	0	15	11.0
9	Сэргэлэн	9	0	0	9	6.6
10	Цагаан-Овоо	10	0	0	10	7.4
11	Баян-Уул	13	0	0	13	9.6
12	Чойбалсан	8	0	0	8	5.9
13	Чулуунхороот	10	0	0	10	7.4
14	Хэрлэн	8	0	0	8	5.9
	<b>Нийт</b>	<b>136</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>136</b>	<b>100</b>

Зөвлөмжийн нэгтгэлээр өндөр эрсдэлтэй гэж тодорхойлсон Халхгол, Матад сумдад 9-10, Баяндун, Булган, Гурванзагал, Хөлөнбуйр, Цагаан-Овоо, Баян-Уул, Чулуунхороот сумдад 10 болон түүнээс дээш тооны зөвлөмжийг өгсөн байна.

“Төрийн сангийн үйл ажиллагаа”-нд хийгдсэн дотоод хяналтаар 2018 оны 01 дүгээр сард нийт 136 зөвлөмж өгөгдсөн нь зөвхөн төлбөр тооцооны хяналтын үйл ажиллагаатай холбоотой байна. Өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 3 дугаар сард 100 хувь гэж тайлагнасан ч эдгээр зөрчлүүд нь аудитын явцад давтан илэрсэн.

“Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам”-ын 5.4-д “Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналтаар ажиллаж дотоод хяналт хариуцсан эрх бүхий албан тушаалтан тухайн төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг дахин үнэлж, баталгаажуулан дотоод хяналтын тайланд тусгана” гэж заасан ч тайланд анх тооцоолсон сумдын өөрсдөө тодорхойлсон эрсдэлийг дахин үнэлж, баталгаажуулалгүй шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

Хяналтаар илэрсэн зөрчлийн дагуу дахин үнэлэхэд бага эрсдэлтэй гэж үнэлсэн 7 сумын Төрийн сан өндөр эрсдэлтэй сумдаас илүү зөрчилтэй байна. Хяналтын журамд зааснаар сумдын төрийн сангийн мэргэжилтэн өөрийн ажлыг загварчилсан саналын хуудасны дагуу бөглөж байгаа, харин аймгийн Төрийн сангийн дотоод хяналтын ажилтан журмын 5.1.3-д заасан эрсдэлийн түвшний зураглалыг хийгээгүй нь эрсдэлийг үнэн зөв үнэлэхэд нөлөөлсөн байна.

Цаашид СТСХ-ийн дотоод хяналтын мэргэжилтэн журамд заасны дагуу эрсдэлийн үнэлгээг дахин хийж баталгаажуулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.


## **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Төрийн сангийн эрх зүйн орчныг сайжруулах шаардлага байна.

2. Төсвийн тухай хуульд заасан төрийн сангийн нийтлэг чиг үүргийг нэмэгдүүлж, тогтолцоог чиг үүрэгтэй уялдуулж өөрчлөх шаардлагатай байна.
3. Зарим сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод, жишиг зааварт заасан холбогдох чиг үүргүүдийг бүрэн тусгаагүй байна.
4. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт Төрийн сангийн үйл ажиллагааны үр нөлөөг сайжруулах зорилтууд тусгагдсан ч хүрэх үр дүнг тодорхойлоогүй, биелэлтийг бодитой үнэлээгүй байна.
5. Төрийн сан нь хуульд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.
6. ЗГСМУС нь хэрэгцээ шаардлагыг хангаж байна.
7. Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Утас: 7018-4111, Факс: 7018-0184

2018.11.05 № 4/1850

төний \_\_\_\_\_ чиг № \_\_\_\_\_ -г


Г ДОРНОД АЙМГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б. БОЛОРТУУЛ ТАНАА

Г Аудитын тайлан, дүгнэлтийн харйу

Дорнод аймгийн Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнгийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан дүгнэлттэй танилцан хариуг хүргүүлж байна. Үүнд:

1. Аймгийн төвийн сум болох Хэрлэн суманд санхүүгийн алба байгуулах асуудлыг холбогдох дээд байгууллагатай зөвшилцөн зохион байгуулж шийдвэрлэж ажиллана.
2. Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 65 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын журам" -ын 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтад тусгагдсан аргачлалын маягтын дагуу өмнөх жилийн дотоод хяналтаар илэрсэн зөрчил, анхаарах асуудлын дагуу 2018 оны эрсдлийн үнэлгээг хийж дотоод хяналтын төлөвлөгөөг батлуулан ажиллаж байна.
3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний ажлын чиг үүргийг тодорхой болгон ажлын байрны тодорхойлолтод тусгуулан баталгаажуулахаар эрх бүхий албан тушаалтанд чиглэл өглөө.
4. Сумдын санхүү албаны дарга, мэргэжилтэн, нягтлан бодогчдын ажлын байрны тодорхойлолтыг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар"-ын дагуу чиг үүргийг бүрэн тусгуулж мөрдүүлж ажиллана.
5. Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой хууль, Засгийн газрын тогтоол, төрийн сангийн үйл ажиллагааны болон бусад журам зааврын хэрэгжилтийг хангуулан мөрдөн ажиллах үүднээс төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгддөг хууль, эрх зүйн актын цаглабарт төлөвлөгөө, сумын төрийн сан, санхүүгийн албаны үйл ажиллагааны өөрийн үнэлгээ хийх улирлын тайлангийн загвар, санхүүгийн албанд шинээр болон түр орлон ажиллаж байгаа төсөв, төрийн сангийн мэргэжилтэн, санхүүгийн албаны даргыг дадлагажуулах сургалтын удирдамжийг гарган ажиллаж байгаа болно. Цаашид холбогдох хууль болон заавар журмыг хэрэгжүүлэх талаар оновчтой арга хэмжээ авч ажиллах болно.
6. Төсвийн ерөнхийлэн захирагчийн Сангийн сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан ажлуудын гүйцэтгэлийг бүрэн гэрээж, үр дүнд хяналт тавин хэрэгжүүлэн ажиллана.

ЗАСАГ ДАРГА  М.БАДАМСҮРЭН



01 1973

## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

### **Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага-д**

1. Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй зарим хууль тогтоомж, журам заавруудыг бусад эрх зүйн акттай уялдуулах, төсвийн төлөвлөлтийн үе шаттай холбоотой чиг үүргийг хууль, журамд тусгуулах асуудлыг холбогдох газарт уламжлах.

### **Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч М.Бадамсүрэн-д**

1. Хэрлэн суманд санхүүгийн алба байгуулах эсэх асуудлыг холбогдох дээд шатны байгууллагатай зөвшилцөж шийдвэрлэх.
2. Төрийн сангийн үйл ажиллагааны эрсдэлийг бодитой тооцож, хяналтын хүрээг нэмэгдүүлж, үр нөлөөг сайжруулах.

### **Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Бат-Өлзий-д**

1. Төрийн сан болон Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн санхүү, төсвийн асуудалтай холбоотой чиг үүргийг тодорхой болгох.

### **СТСХ-ийн дарга Н.Базаррагчаа-д**

1. Зарим сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод жишиг зааварт заасан холбогдох чиг үүргүүдийг бүрэн тусгуулах.
2. Төрийн сангийн төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой хууль, ЗГ-ын тогтоол, төрийн сангийн үйл ажиллагааны болон бусад журам зааврыг бүрэн мөрдөж ажиллах.
3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Сангийн Сайдтай байгуулсан гэрээнд тусгагдсан ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бодитой тооцох.

Аудитаар нийт 760,0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 3,7 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 1 албан шаардлага өгч, хариуцлага тооцуулах 1 санал, 7 зөвлөмж өгч ажиллалаа.

Иймд аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 02 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.





**ДОРНОД АЙМАГ ЗАСАГ ТӨРИЙН  
ХУДИГАЛЛАГАА  
МТ**

**Төгсөх ажил тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүтэн эрхийн хүрээнд Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд гүйцэтгэлийн аудит хийх явцад дараах зарчмыг илэрхийлнэ:

Гуравчигал, Давбалцар, Чойбалсан, Цэцэг-Орлоо сумын төсвийн байгууллууд нь өмнөдүйн 2017 оны хэлэйн амралтын мөнгөйг өртөгдөдөг явцад эхлээд хэлэйн амралтын өртөгрийг дундаж цалинд дамжуулахыг тооцож, 2308719 төгрөгийг илүү, 1132824 төгрөгийг дутуу, Гуравчигал сумын нутгийн захиргад хэлэйн амралт үр дүнийг урамшууллыг аймгийн болон сумын Засаг даргын захирамжаар давхардуулан 293521 төгрөгийг олгосон байна.

Дэвж сүгийн төсөв байгууллагуудын өртөг нь өртөггүй болон нэг нь өртөггүй хэлэйн амралтын мөнгөйг 2732284 төгрөгөөр эхлээд тооцож, урамшуулалын 293521 төгрөгийг дамжуулахыг олгосон нь, Нэгдсэн Бодол Дундгайн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д " ... ажил гүйцэтгэгч төрийн сангийн амралтын мөнгө, баталгаануудыг", Эрүүл мэнд, хийгээд хамгааллын Сайдан 2020 оны 180 дугаар тушаалаар баталсан "Эхлээд амралтын өртөгөөр тооцох журмыг" 4-н 7-д "Төрийн сангийн мөнгөний эхлээд амралтын өртөггүй тодорхойлохын өмнө хэлэйн амралтын мөнгөний эхлээд амралтын өртөггүй тооцож, оруулж куцарчлан дараа цалин мөнгөйг дамжуулах эрүүлж тооцохгүй" гэх зарчмыг тус тус өргөсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-г "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчилтэй барагдуулах аяг тавих, албан хариуцагчид өгөх, хууль тогтоомж, эрх зүйн сан хэмээх тогтоосон бусад үндэслэлийн бэлтгэсэн болгох санхүүг хяналтад байгууллага тавих", Монгол Улсын Ерлөхийн аудитын 2018 оны АББ дараа тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аяг тавих, албан хариуцагчид өгөх, хууль тогтоомж, эрх зүйн сан хэмээх тогтоосон бусад үндэслэлийн бэлтгэсэн болгох санхүүг хяналтад байгууллага тавих" гэх зарчмыг илэрхийлж өргөсөн нь, 3.1.3-д "Бүрэлдэж өгөх төлбөр тооцоо зөрүүлж тооцож олгосон"-д төлбөрийн аяг тавихыг ороон хяналтад үндэслэл ТОГТООХ нь.

1. Дутуу тооцон олгосон 1132824 төгрөгийг холбогдох ажиглуудад олгож, илүү тооцон 2308719 төгрөг, дамжуулахыг олгосон урамшуулалын 293521 төгрөгийг хяналтад тавих байгууллагын дэргэ, нэгдсэн бодол хэрвэр төлүүлэн Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь 10007004401 тоот дансанд төвлөрүүлнэ.

2. Ажлын баазтайгай 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлж айлмгийн Засаг дарга М.Бадарцагийн, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Базаррагчааг нэрт хэрүүлүүлнэ.

**АСТЫГ**

**ТОГТООСОН**

**ХЭЛТЭСНИЙ ДАРГА БӨГӨӨД  
АУДИТЫН АЖИРАГЧ**

В.ЦЭНГЭЛМАА

**АЖЛАХ АУДИТСР**

Д.НАРМАНДАХ

**ЭРӨВЧӨӨРСӨН**

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

М.САДМАСҮРЭН

**САНХҮҮ ТӨРИЙН САНГИЙН  
ХЭЛТЭСНИЙ ДАРГА**

Н.БАЗАРАГЧАА

1. Аяг, албан хариуцагчид баазтай төлбөрийг өмнөдүйн Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 25.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тасалсан албан мөнгөнийг, төлбөрийн мөнгөний аяг тавихыг нь байгууллагаас тасалсан өмнөдүйн хэлэйн амралтын мөнгөнийг өртөггүйг эхлээд амралтын өртөггүйг тооцож, оруулж куцарчлан дараа цалин мөнгөйг дамжуулах эрүүлж тооцохгүй" гэх зарчмыг илэрхийлж өргөсөн нь, 3.1.3-д "Бүрэлдэж өгөх төлбөр тооцоо зөрүүлж тооцож олгосон"-д төлбөрийн аяг тавихыг ороон хяналтад үндэслэл ТОГТООХ нь.

**2018 оны 11 сарын 5-ны өдөр 11.11.05**

**Төгсөх ажил тухай**

№	Байгууллагын нэр	Төрийн сангийн өртөг	Мөнгөний дүн	
			Илүү	Дутуу
1	Гуравчигал сумын ББС	Үр дүнийг урамшуулах дамжуулах өртөг	293 521	-
2	Гуравчигал сумын БМТ	Эхлээд амралтын мөнгө илүү дутуу олгосон	1 328 186	28 947
3	Давбалцар сумын сумын Мөнгө	Эхлээд амралтын мөнгө илүү дутуу олгосон	304 128	126 626
4	Цэцэг-Орлоо сумын ББС	Эхлээд амралтын мөнгө илүү дутуу олгосон	382 282	85 987
5	Чойбалсан сумын ББС	Эхлээд амралтын мөнгө илүү дутуу олгосон	913 203	602 282
<b>Нийт дүн</b>			<b>2 888 340</b>	<b>1 132 924</b>

